

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРААР 2022-2025 ОНД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ҮР ДҮН, ЗАРЦУУЛАЛТАД ХИЙХ ТӨСВИЙН
ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.10.30

Богд

Нийтийн сонсгол Богд сумын Соёлын төвийн Урлаг зааланд 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 14 цаг 34 минутад эхлэв.

Малын тоо толгойн албан татвараар 2022-2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, зарцуулалт, чанар хүртээмж, иргэний хяналт, тэдний санал дүгнэлтийг сонсох зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгууллаа.

Сонсгол даргалагчаар Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, төсөв, эдийн засгийн бодлого төлөвлөлт хөгжлийн бодлого зохицуулалтын хорооны дарга Д.Мөнх-Эрдэнэ, сумын ИТХ-ын дарга С.Баттогтох, Нарийн бичгийн дарга Ц.Оюунбилэг, Сонсголд тайлбар мэдээлэл өгөхөөр дуудагдсан албан тушаалтнаар Сумын Засаг дарга О.Өлзийбадрах, Засаг даргын орлогч А.Мөнх-Очир, Төсөв, төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмар, Татварын байцаагч Ц.Оюунбаяр, журмын дагуу оролцогчоор бүртгүүлсэн оролцогч Р.Отгон, П.Энхтуул, Д.Дэмбэрэл, Ю.Нэргүй, Н.Цэрэндулам, Н.Нарантуяа, Д.Бадарч, А.Хишигдорж, П.Энхцэцэг, Б.Түвшинжаргал, Б.Өлзийбат, О.Батдэлгэр, Ц.Пүрэвбаатар, Д.Баярсайхан, О.Мөнхдэлгэр, Б.Цэндсүрэн ажиглагчаар Ч.Эрдэнэчулуун, Б.Цэвэлсодном, Б.Анхтулга, Э.Отгонцэцэг, Ш.Бүрэнтөгс, Б.Мөнхцэцэг, Ц.Цэрэндорж, Б.Энхтүвшин, О.Нямдорж, Б.Сумъяабазар, иргэдийн төлөөлөл нийт 41 хүн оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Малын тоо толгойн албан тавараар 2022-2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, зарцуулалтад хийх төсвийн хяналтыг сонсголын тухай

СОНССОН нь:

Д.Мөнх-Эрдэнэ (Сонсгол даргалагч): Нийтийн сонсголыг нээж үг хэлж, нийтийн сонсголын тухай хуулийн мэдээллийг өгч, нийтийн сонсгол зохион байгуулах хөтөлбөр, сонсголын дэгийг танилцуулж батлуулав.

Сонсголд дуудагдаж ирсэн албан тушаалтан: Татварын байцаагч Ц.Оюунбаяр
Малын тоо толгойн албан татвараар 2022-2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, зарцуулалтын тухай танилцуулав. /танилцуулгыг хавсаргав/.

Сонсгол даргалагч: Сонсголын асуудалтай холбоотой асуулт асуух оролцогч байна уу? П.Энхтуул, А.Хишигдорж

П.Энхтуул (оролцогч): Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Малчдын сургалт сурталчилгаанд 10 сая төгрөг зарцуулсан гэж

байна энэ сургалт хаана явагдсан юм бэ? Энэ нь малчдад аль хэр хүрээмжтэй болсон юм бол би л лав сонсоогүй юм байна энэ талаар тайлбар, мэдээлэл авья.

Сонсгол даргалагч: Тайлбарыг Төсөв төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмар хийе.

Ж.Мягмар (Төсөв, төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч): Энэ зардал нь Гучин-ус суманд малчдын зөвлөлгөөн гэж хийсэн тэнд 100-аад малчин оролцсон энд тээвэр, хоол ундны зардалд 10 сая төгрөг зарцуулагдсан.

А.Хишигдорж (оролцогч): Сайн байцгаана уу? Малын хөлийн татвараар гүн өрмийн худаг гэж байна энэ усыг гаргаад багийн нийт иргэдэд хүрэлцээ ямар байна эсвэл хувь хүнд гаргаж өгөөд байна уу? Барьсан худгууд нь хол байршилтай ашиглагдахгүй ганц нэгхэн айлын хэрэгцээ хангасан байдалтай байх юм.

Ж.Мягмар (Төсөв, төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч): Худаг усны хувьд 7 багаас санал аваад тэр саналаа БИНХ-аар эрэмбэ тогтоож тэр саналуудыг нэгтгэж ЗДТГ-ын ажлын хэсэг сумын ИТХ-д оруулан батлагдаж гарч ажил хийгддэг байгаа.

П.Энхтуул (оролцогч): Малын эрүүл мэндийг хамгаалахад 10 сая төгрөг гэж байна энд ямар малчдын эрүүл мэндийг хамгаалдаг юм бол гэж асуумаар байна.

Ж.Мягмар (Төсөв, төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч): Энд манай сум мал эмнэлэгийн 2 аж ахуйн нэгжтэй энэ аж ахуйн нэгжүүд багуудаар тойрч вакцин, тариа туулга хийдэг энд гарсан зардлыг л хэлээд байгаа юм.

Сонсгол даргалагч: Сумын Засаг дарга О.Өлзийбадрах нэмэлт тайлбар хийнэ.

О.Өлзийбадрах (Засаг дарга): Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нийтийн сонсголыг бид заасан хуулийн хугацаанд зохион байгуулж байна. Өнөөдрийн сонсголд оролцогч, ажиглагчаар оролцож байгаа та бүхэнд талархал илэрхийлье.

Оролцогчдын асуултад ажил хариуцсан албан хаагчид хариулт өглөө сумын Засаг даргын хувьд нэмэлт мэдээлэл өгье гэж бодож байна. Хэдийгээр өмнөх онд хийгдсэн ажил ч гэсэн малын тоо толгойн албан татвар юунд зориулагддаг, ямар зориулалттай байдаг төлөвлөлт нь ямаршуухан байдаг талаар та бүхэнд сая татварын байцаагч, санхүү албаны дарга нар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. 2021 оноос Монгол Улсын хэмжээнд малын хөлийн татвар авч эхэлсэн. Энэ хуулиар тухайн сумын малын тоо толгойн албан татварыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоодог. Татварын төлөлт харьцангуй тааруу байгаа зарцуулалттай холбоотой асуулт асууж байна. Малчдын сургалт сурталчилгаа 10 сая төгрөг энэ нь тухайн үед Гучин-ус суманд говийн бүсийн малчдын зөвлөлгөөн болсон энд оролцсон

малчдын тээвэр шатахуун, хоол унд, байрласан байр гээд олон зардал гарч байгаа 100 орчим малчин сумаас оролцсон юм билээ үүнд зарцуулсан юм билээ. Манай сум 1140 малчин өрхтэй 318765 толгой малтай малын тоо толгойн албан татвараар малчин бүрийн эрүүл мэндийг хамгаалах асуудал боломж бололцоо хомс байгаа энэ бол татвар төлөлттэй холбоотой А.Хишигдорж асууж байна худаг ус хувь хүнд гаргаж өгч байна уу? нийтэд гаргаж өгч байна уу? гэж асуулаа энэ бол нийтэд гаргаж өгч байгаа энэ бол тухайн орон нутгийн хөгжлийн сангийн хуулийн хугацаа байдаг энэ хугацаанд бид багийн иргэдийн Нийтийн Хурлыг хуралдуулж санал авдаг ингээд олонхийн санал авсан ажлуудыг эрэмбэлж гаргаж ирнэ энд олон талын үзүүлэлт харна эрэмбэлсний дагуу ЗДТГ-аас тодорхой хэмжээний төсвийг тавьж сумын ИТХ-д оруулж батлуулдаг. Уст цэг бол төрийн өмч, уст цэгийг хэн нэгэн эзэмших хууль эрх зүйн зохицуулалт байхгүй бүх уст цэг төрийн өмч тэгэхлээр энэ орон нутгийн хөгжлийн сангаар гаргасан гүний худаг бол нийтийн өмч манай суман дээр түгээмэл ажиглагдаж байгаа зүйл байна хэн нэгэн хувиараа юмуу дангаараа ах дүүсээрээ уст цэгийг эзэмших гээд байдаг зүйл байдаг юм билээ би багийн иргэдийн Нийтийн Хурал дээр хэлж байгаа тийм зүйл байхгүй шүү хуулиараа уст цэг төрийн өмч тийм учраас энэ ОНХС-р гаргаж байгаа гүн өрмийн худгийг 10 жилийн хугацаатай гэрээ хийж байгаа гэрээнд минийх чинийх гэсэн ойлголт байхгүй гэж хэлж байгаа. Тэгэхлээр эрэмбэлээд гаргаж байгаа худаг болохоос биш хэн нэгэн даргын, хэн нэгэн иргэний үзэмжээр худаг гаргаж байгаа асуудал огт байхгүй гэдгийг хариуцлагатайгаар хэлье. Малын эрүүл мэндийг хамгаалах 10 сая төгрөг ямар зүйлд зарцуулагдсан гэж асууж байна малын тоо толгойн албан татвар зарцуулагдах 12 заалттай үүнд л зарцуулагдана хэрвээ өөр зүйлд зарцуулах юм бол хуулийн хариуцлага хүлээнэ. Сумын ИТХ хуулийн хүрээнд л төсвийг нь баталж өгч байгаа өөр зүйлд зарцуулах ямар ч боломжгүй манай сум 1,015,562 га газартай 7 багтай 2 аж ахуйн нэгж малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа манай 2 нэгж айл бүрд хүрч үйлчлэх боломж бололцоо хомс байгаа энэ бол хүн хүчтэй, зардал мөнгөтэй холбоотой тийм учраас хуулинд нь өөрөө малын эрүүл мэндийг хамгаалах төсөл баталж өгөө энэ хүрээнд тухайн вакцин, тариа туулгаа хийхдээ хүн хүч ажиллуулж цалин хөлсийг нь өгөх мөн шатахууны дэмжлэг үзүүлэх гэх мэт малын эрүүл мэндийг хамгаалах зүйлд зарцуулагддаг юм.

Сонсгол даргалагч: Өөр асуух асуулттай оролцогч байна уу? оролцогч Н.Нарантуяа, Д.Дэмбэрэл, Р.Отгон, А.Хишигдорж, Н.Нарантуяа, Д.Энхцэцэгээр таслая.

Н.Нарантуяа (оролцогч): Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өвс

тэжээлийг хаанаас яаж татаж байна орон нутгаас авч байна уу?

Д.Дэмбэрэл (оролцогч): Малын хөлийн татварыг 12 ажилд зарцуулна гэж байна өөр зүйлд шилжүүлэн зарцуулж болох уу? Татвар төлөлт муу байдаг юм байна. Гүйцээж авах болоогүй юм уу? Татварын байцаагч дээр багийн Засаг дарга нар ажиллаж байх ёстой байх энд би багийн Засаг дарга нар муу ажиллаж байна гэж хэлмээр байна.

Сонсгол даргалагч: Засаг дарга тайлбар хэлье.

О.Өлзийбадрах (Засаг дарга): Н.Нарантуяагийн асуултад хариулья. Өвс тэжээл хаанаас яаж авч байна вэ? орон нутгийн хувьд гарц сайн байлаа дотоодоос авч болоогүй юм уу гэж байна. Энд боломжгүй юм бүх зүйл хуулинд захирагдаж байгаа юм хэн нэгэн хүн дур зоргоороо ажиллавал энэ улс оронд эмх замбараагүй болно энэ бол худалдан авах тухай хууль, тендрийн тухай хууль гэж байдаг 20 сая төгрөгөөс доош үнэлгээтэй ажил, бараа үйлчилгээг харьцуулалтын аргаар, 20-150 сая төгрөг болохоор мөн харьцуулалт нээлттэй зарлана 150-с дээш бол нээлттэй тендер зарлана энэ жилийн хувьд 69,9 сая төгрөг өвс тэжээлийн бэлтгэхэд тавьсан 3 компани орж ирсэн хамгийн бага үнийн саналтай компанийг авсан ингэхдээ бид нар ЗДТГ-аас ажлын хэсэг гарч техникийн тодорхойлолтын шаардлагыг тавьж өгч байгаа энэ жилийн хувьд цаг агаар ямаршуухан байхав таарсан мөнгөндөө ямар өвс, тэжээл худалдаж авах вэ худалдаж авч байгаа өвс тэжээлэндээ ямар стандарт тавих вэ гэж олон зүйл шаардлага тавьсан шинэ ургацын ногоон өвс дээр нь Монгол Улсад дагаж мөрдөгдөж байгаа стандартыг авсан ингээд тендер зарлаад тендерт 3 аж ахуйн нэгж ороод эдгээрээс хамгийн үнийн бага санлаар "Их наяд ази" компани 61,900,0 төгрөгөөр гүйцэтгэсэн тэгэхлээр бид нар дотоодын аж ахуйн нэгж буюу сумын аж ахуйн нэгжүүдээс авах давуу байдал олгох боломж байхгүй юм ингээд давуу байдал олгоод өгчих юм бол нөгөө ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзээд бид нар хамтдаа АТГ- руу явна тиймээс бид хуулийн хүрээндээ энэ ажлуудыг зохион байгуулж байгаа. Д.Дэмбэрэл гуайн асуултад хариулахад малын тоо толгойн албан татварыг хуулинд заасан 12 төрлийн ажилд л зарцуулна өөр зүйлд зарцуулж болохгүй. Татвар төлөлт муу байна гэж байна 2021 оноос хойш авч эхэлсэн 5 жилийн хугацаанд 2024 онд тэглэсэн татвар хамгийн сайн авсан жил 2021 онд төлөвлөгөө 112,104,950 төгрөг гүйцэтгэл нь 78,772,085 төгрөг үлдэгдэл нь 33,332,865 төгрөг, 2022 онд 165,394,000 төгрөгнөөс 50,939,050 төгрөг үлдэгдэл нь 114,454,950 төгрөг 2023 онд 206,534,000 төгрөгнөөс 109,027,350 үлдэгдэл нь 97,506,605 төгрөг, 2025онд 159,357,500 төгрөгнөө 88,036,756 төгрөг үлдэгдэл нь 71,320,747төгрөг нийт үлдэгдэл 316,0 сая төгрөг байна. Тантай санал нэг байна малын тоо толгойн

татвар бол манай малчдын үүрэг хариуцлага уул нь нэхүүлээд шаардуулаад байлгүй өөрөө хэдэн мал тоолуулсан хэдийд татвараа төлөхөө бүгд мэдэж байгаа төлөх л хэрэгтэй энд би хэн нэгэн албан хаагчыг буруутгах гэхээс илүүтэйгээр иргэдийн өөрсдийн ухамсрын асуудалтай холбоотой гэж бодож байгаа нөгөөтэйгүүр албан хаагчидтай холбоотой асуудал байгаа энэ орлого орж ирэхгүй учир бид төлөвлөсөн ажлаа хийж чадахгүй байгаа мөнгөгүй учир тэгэхлээр бид орлогоо 1140 өрх мал бүхий өрхтэйгөө 1240 өрхтэй 2025 онд 159,0 саяаас 88,0 сая төгрөг орсон үүний 50 хувь нь автын үзлэгээр орж ирсэн тэгж барьцаалж нөгөө хүмүүсээ шахаж шаардаж байж орлогоо олж ирж байгаа юм. Энэ жилийн эцсийн мал тооллогоор сумын удирдлагууд, багийг Засаг дарга нар бид тусгайлан төлөвлөгөө боловсруулж ажиллая гэж ярьж байгаа. Манай багуудаас 1-р баг 21,389,650, 2-р баг 20,658,350, 3-р баг 22,194,650, 4-р баг 18,920,150, 5-р баг 23,620,000, 6-р баг 16,515,150, 7-р баг 6,657,900 төгрөг буюу 140,016,050 төгрөг дутуу байна хэн хэдэн төгрөг дутуу гэдэг нь бүгд байгаа үүнийг иргэдэд мэдээлж болохгүй хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл учраас тэгэхлээр 2021 оноос хойш татвар төлөөгүй малчид нэлээдгүй байгаа энэ нь өөрсдөө малаа малладаггүй малаа эцэг,эх дээрээ тавиад өөрөө Улаанбаатар хот эсвэл Өмнөговь аймаг руу ажил хийгээд явчихсан багийн Засаг дарга, татварын байцаагчид олддоггүй хэсэг нөхөд бий энд ямар арга хэмжээ авах вэ гэж ярилцаад энэ оны жилийн эцсийн тоогоор нилээдгүй барагдуулахаар төлөвлөж байгаа цаанаасаа бол дансыг нь хаа гэж байгаа татвар төлөөгүй малчдын дансыг нь хаая гэж бодье дансанд нь барилт хийчихээр хүний амьдрал баялаг манай малчид өдөр тутам орлого байхгүй хавар, намар 2 жаахан орлого орно тэгэхлээр иргэдээ бодоод ний нуугүй үнэнээ хэлэхэд ийм шийдвэр гаргаж чадахгүй байна уул нь хуулиараа бол дансыг нь хаагаад явж болно амьдрал болсон хойно байх байхгүйн зовлон байгаа олон асуудал байгаа тийм учраас шууд хууль хэрэгжүүлж чадахгүй байгаа тэгэхдээ оны эцсээр төлөвлөгөө гаргаж ажиллана болохгүй бол ирэх жилээс дансыг нь хаахаас өөр аргагүй болж байна сумдууд бол хаагаад явж байгаа юм билээ тэгэхлээр энэ сонсголд оролцож байгаа та бүхэн ойр дотны малчидад малын тоо толгойн албан татвараа төлөөгүй бол төлөөрэй ийм учиртай юм билээ шүү гэдгийг хэлэхийг та бүгдээс уриалж байна. Малын тоо толгойн албан татвараар юу хийгдэж байгааг ЗДТГ-ын пейж хуудсаар бүгд нээлттэй явж байгаа багийн Засаг дарга нар ажлаа муу хийж байгаа юм биш үү гэж байна энд санал нэг байна энэ бас хуулиараа манай багийн Засаг дарга нар анхан шатны ажил хариуцаж байгаа албан хаагчид нар өдөр тутам статистик мэдээлэлтэй зууралдуулдаг ажил байдаг юм байна байнгын судалгаа тэгэхлээр багийн дарга нарыг ажлаа сайжруулах малын тоо

толгойн албан татварыг төлүүлэх тал дээр сумын Засаг дарга тодорхой төлөвлөгөө гаргаж чиглэл үүрэг болгож өгье.

Сонсгол даргалагч: Засаг даргад баярлалаа. Оролцогч Р.Отгон

Р.Отгон (оролцогч): Энэ жил 1 боодол өвс, 1 шуудай хивэгийг ямар үнэтэй худалдаж авч байна?

А.Хишигдорж (оролцогч): Малын тоо толгойн албан татвараар худаг гаргажээ ашиглагдахгүй, хэрэгцээгүй худаг байх юм ганц нэг тэмээтэй айл л уувал ууна уухгүй бол байж байдаг үүнийг яах юм.

Н.Нарантуяа (оролцогч): Малын чанар сайжруулах гэж байна малын чанарыг яаж сайжруулж байна би ойрд сонсоогүй юм байна.

Сонсгол даргалагч: Засаг дарга хариулт өгье.

О.Өлзийбадрах (Засаг дарга): Р.Отгон гуай үнийн талаар асууж байна энэ бол зах зээлийн үнээр л авч байна 1 боодол өвсийг 16-18 мянган төгрөгөөр Дорнодоос өвс татасан зах зээлийн үнийг харьцуулж тендерийг зарласан сумын аюулгүй нөөцөд 2000 боодол ногоон өвс, 1000 шуудай хивэг ирсэн энийг хэвгийг 28,000, өвсийг 16-18 000 төгрөгөөр тооцоолж тендер зарласан манай сумын хувьд нэг хүндрэлтэй юм байна ямар ч тендер зарласан тээвэрийн зардал гэж аюултай юм байна нэг том тэрэг ирж очиход дунжаар 5 сая төгрөг тэгэхлээр тээвэрлэлтийн зардал энэ тэрийг бодож байж дундаж үнийг гаргаж тавьж байгаа бид зарлахдаа үнэ тавихгүй тоо хэмжээг нь тавьж өгдөг 2000 боодол өвс, 1000 шуудай хивэг авна үүнийг нийлүүлэх боломжтой аж ахуйн нэгжүүд орж ирээч гэж байгаа боломжтой аж ахуйн нэгжүүд орж ирээд хамгийн бага үнээр нийлүүлэх аж ахуйн нэгжийг үнэлгээний хороо шалгаруулаад сумын Засаг даргад зөвлөмж хүргүүлээд сумын Засаг дарга гэрээ байгуулах эрхийг нь олгоод гэрээ байгуулагдаад хугацааг нь гэрээндээ зааж өгөөд тухайн хугацаандаа нөгөө компани өвс тэжээлээ нийлүүлээд, нийлүүлсэн өвс тэжээлийг тусад нь ажлын хэсэг гараад нөгөө бид нарын тавьсан шаардлагад нийцэж байна уу? үгүй юу гэдгийг шалгаж үзээд хүлээж аваад болж байна гэж үзвэл мөнгийг нь шилжүүлдэг. А.Хишигдорж малын хөлийн татвараар гаргасан худаг чинь ашиглагдахгүй байна түүнийг яах ёстой вэ? гэж байна энэ бол орон нутгийн хөгжлийн сангаар эрэмблэж оруулж ирж байгаа худаг аль баг дээр ямар худаг ашиглагдахгүй байгаа юм та надтай уулзаад хэлээрэй тухайн орон нутгийн хөгжлийн сангаар оруулж ирсэн нөхөд чинь судалгаагаа гаргаж өгсөн ш дээ уул нь орон нутгийн хөгжлийн сангийн төсөл чинь нийтийг хамарсан байх ёстой. Н.Нарантуяа гуайн асуултад хариулахад малын чанар сайжруулах асуудал гэж ярьлаа энэ ажил манай суманд хийгдээгүй малын хөлийн татвараар ийм 12 төрлийн ажлыг хийж болно гэсэн

ангилал байгаа юм энэ ангилал нь 4.5.5-д байгаа энэ дээр нэг ч төгрөг зарцуулагдаагүй хэрвээ орон нутгийн хөгжлийн сангаар малын чанарыг сайжруулах ажил дэмжигдээд ороод ирвэл малын хөлийн татвараар ажил хийж болно гэсэн үг бусдаар бол манай суманд хийгдээгүй ажилд төсөв мөнгө тавигдсан асуудал ерөөсөө байхгүй үндсэндээ энэ 12 чиглэлийн ажлаас манайд худаг ус, малын эрүүл мэндийг хамгаалах дээр, малчидад зориулсан сургалт сурталчилгаан дээр, өвс тэжээлийн нөөц ийм 4-5 зүйл дээр л ажил хийгдэж байгаа юм 12 ажилд тавигдах боломж байхгүй 159,0 сая төгрөгийн орлоготой малын хөлийн татварын орлоготой тэрийгээ бүрэн гүйцэд авч чадахгүй сум 70,80 сая төгрөгийг 12 ажил хийнэ гэж байхгүй ер нь орон нутгийн хөгжлийн сан малын хөлийн татварыг цомхон хүрээмжтэй ажилд хийх л шаардлага байгаа юм говийн бүс нутаг газар нутаг томтой усан хангамж муу иймээс гүн өрмийн худаг гаргах зайлшгүй шаардлага байгаа одоо 32 цэг дээр гүн өрмийн худаг гаргах асуудал яригдаж байгаа жил бүр 1-2 худаг төсөвтөө тааруулж шийдээд явж байна уул нь төсөв байдаг бол 5,6 гаргаад өгөх боломж бололцоо хэрэг байх юм.

Сонсгол даргалагч: оролцогч Д.Энхцэцэг

Д.Энхцэцэг (оролцогч): Энэ өдрийн мэнд хүргэе. Малын хөлийн татварыг зарим нэг нь жил бүр төлөөд байдаг төлсөн нь энэ нь цаашаа ажил хийгдээд яваад байдаг төлөөгүй нэг хэсэг нь ард нь үлдээд төлснийгөө завшаад яваад байдаг тусламжийн өвс, тэжээл янз бүрийн юм ирдэг тэгэхэд би ч малчин би авна тэнд байгаа ах дүү нартаа авна тэнд манай малчин байдаг гээл багийн бүх хүмүүс дайрдаг 1 боодол өвс ч авна 1 шуудай хивэг ч байсан дайрдаг энийг багийн дарга нар зохицуулаад малын хөлийн татварыг төлдөг тийм хүмүүст хувааж өгдөг тэр хүмүүс тусламж юмаа эдэлдэг татвар өгөөгүй хүмүүст тусламж авдаггүй зохицуулалтыг багийн дарга нар хийж болдоггүй юм уу. Багийн дарга нар хариуцлага муутайхан байнга л эзгүй байдаг албан ажлын цагаар тэд юу хийж явдаг юм ажлынхаа ерөөнд ихэнхдээ байдаггүй багийн дарга нар яах гэж сонгогддог юм бодвол Богдын ард түмний сайныг дэмжиж саарыг нь засах гэж дарга нар сонгогддог байлгүй энэ олон дарга нар багийн хэдхэн ард түмнийг татварыг нь аваад болохгүйг нь болгохын төлөө зүтгээд болж байгаа нэгийг нь урамшуулаад татвар энэ тэрийг нь шамдаж авч яагаад болдоггүй юм зарим нь жил бүр төлөөл байдаг зарим нь ард нь үлдээл авах болохоор хамгийн түрүүнд авдаг ийм ажлуудаа зохицуулж л ажилламаар байна.

О.Өлзийбадрах (Засаг дарга): Малын тоо толшойн албан татварыг зарим нь төлөөд зарим нь төлөхгүй юм энэ яагаад байна гэж байна би та бүхэнтэй санал нэг

байна малчнаар бүртгүүлчихээд малаа малалдаггүй тусламж дэмжлэг болохоор би ч авах ёстой би ч авах ёстой гэдэг сум орон нутгаас зохиож байгаа ажилд оролцдоггүй тэгээд эрх яриад байдаг энэ тал дээр анхаарч ажиллана багийн Засаг дарга тухайн багийн иргэдтэй л ажиллана энэ тал дээр сумын удирдлагын хувьд анхаарч ажиллана.

Сонсгол даргалагч: Санал хэлэх оролцогч байна уу? оролцогч П.Энхтуул, Л.Зулбаяр

П.Энхтуул (оролцогч): Малын хөлийн татварыг багийн Засаг дарга нар малаа тоолоод тоо гаргадаг тоолсон даруйдаа малын хөлийн татварыг байнга аваад яваад байж болдоггүй юм уу? малчдын сургалт сурталчилгаа гэж байна ирэх онуудад явагдах уу? энэ сургалтад 1000-т малчид л явдаг хэрэв явагдахаар бол цаашид залуу малчдын явуулж байгаачээ гэж хэлье. Энэ 1000-т хэдэн айл өрх малжуулсан юм гэдгээр нь урамшуулж баймаар байдаг залуу малчдыг дэмжих нь чухал байна.

Л.Зулбаяр (оролцогч): Татвараа байнга төлдөг малчдыг 4 жилд ч юм уу буцаан олголт гэх мэт урамшуулал байлгавал зүгээр байх болов уу гэсэн санал байна. Энийг сумын ИТХ хурал татварын хувь хэмжээ тогтоож байгаа юм чинь энд шийдвэр гаргаад явж болох юм биш үү гэсэн санал байна.

Д.Дэмбэрэл (оролцогч): Малын хөлийн татварыг өгдөггүй малчдад авдаг арга хэмжээ гэж байдаггүй юм уу? өгөхгүй яваал байвал даварсаар байгаал та нарын толгой дээр гарчих юм биш үү. Багийн иргэдийн Нийтийн Хурлыг чанартай хийж баймаар байна чанаргүй хурал хийгээд юмаа ярьж чаддаггүй болсон байна. Багийн иргэдийн Хулын дарга чинь хурлаа удирдаад багийн Засаг даргадаа үүрэг өгөөд татвараа хураагаад ажиллаж болмоор санагдаж байна.

О.Өлзийбадрах (Засаг дарга): Бидний ажилд тус нэмэр болж саналаа илэрхийлсэн та бүгдэд баярлалаа. Багийн Засаг даргатай холбоотой асуудал П.Энхтуул гуай ярьсан миний бие ажил хүлээж аваад 1 жил хараахан болоогүй байна ажил хүлээж аваад сумын сайн малчны журмыг боловсруулсан өмнө нь журам байдаггүй байсан юм билээ. Би өмнө нь ч гэсэн би ХХААХҮЯаманд Монгол Улсын хэмжээнд малчдын асуудал хариуцаж байсан манай говийн сум тэр дундаа манай сумын малчид хариуцлагагүй байна яагаад ямар ч нийгмийн хариуцлагын ажилд оролцдоггүй шагнал урамшуулал болохоороо би, би гэдэг өгөхгүй бол энэ өгсөнгүй тэр өгсөнгүй гээд асуудал үүсгэдэг буцаад нийгмийн хариуцлагын хүрээндээ сум орон нутгаас зохион байгуулж байгаа ажилд оролцоочээ аймагт болж байгаа арга хэмжээ байна Богд сумын нэр гарч байна энд оролцооч гэхэд хариу өгдөггүй

малчдын нийгмийн хариуцлагын асуудал байна үүнийг хэлж ярьж ойлгуулах шаардлагатай байна. Тэр үүднээс 11-р сарын 28 нд Малчдын зөвлөлгөөнийг зохион байгуулах гэж байна энд бид сайн муугаа ярилцана цаашид сум, аймаг, улсын сайн малчныг шалгаруулахдаа малын тоо толгойн албан татварыг авч үзнэ манайхан гэнэт шагнал руу орохоороо төлдөг механизмыг хүлээж авахгүй тогтвор сууршилтай жил бүр малын тоо толгойн албан татвараа төлж байсан малчдыг шагнаж урамшуулах тал дээр анхаарч ажиллана үүнийг шагналын жураманд оруулна гэж байгаа мянгат малчдын асуудал ярьж байна монгол улсад хамгийн олон мянгат малчинтай сум Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум байдаг Өвөрхангай аймагт Бүрд сум байдаг манай Богд сум дунд хавьд орно залуу малчид гэж ярьж байна мэдээж залуу малчдыг дэмжих нь зөв гэв гэнэт ажил гарах юм залуу малчдыг явуулья гэхлээр малчид олдохгүй юм сая Ордос руу 2 малчин явуулах гээд судалгаа авсан явах малчин олдохгүй юм тэгээл муу бол хойд захын хар овоохой гэгчээр нөгөө л мянгатдаа хэлэх юм асуудал үүсэх юм үүнийг аль болох асуудал үүсгэхгүйгээр анхаарч ажиллана залуу малчдаа дэмжиж ажиллана асуудлыг хүлээж авна. Л.Зулбаяр ярьж байна энэ маш зүйтэй санал ер нь татварын байцаагч та жил бүр цаг тухайд нь татвараа төлдөг малчдын мэдээллийг маргааш 11 цагаас танилцуулаатах 7 багийн хэмжээнд хичнээн малчин тогтмол татвараа төлөөд байгаа юм хэд нь төлөхгүй байгаа юм энэ мэдээллийг аваагүй байгаа татвараа төлж байгаа малчдыг татвараас нь өөрөөр урамшуулах арга зам юу байна судалья сумын нэрэмжит шагнал өгч байгаа ш дээ энэ дотор малын тоо толгойн албан татвараа тогтмол төлдөг баг бүрээс 3,4 малчдыг шагнаж урамшуулж болно бид овоож оцойтол шагнаж чадахгүй гэхдээ боломжийн хэрээр иргэдээ дэмжих урамшуулах ажлыг зохион байгуулья. Өвс тэжээл тараахад татвар төлсөн малчдад өг гэж байна ер нь сумын аюулгүй нөөц гэдэг бол нийтэд биш онцгой тохиолдолд өгдөг тухайлбал өнгөрсөн хавар Богдын ард 12 айл цасанд боогдсон 2,3 хоног мал нь хоолгүй байж байгаа юм тэгэхлээр бид танайд өвс өгнө танайд өгөхгүй гэж болохгүй байхгүй юу төр өөрөө нийт иргэдэд хүрээх ёстой тэгэхлээр бид нар татвараа төлдөг төлдөггүйгээр нь ялгаж болохгүй нэг талдаа сайн ч нөгөө талдаа бид үндсэн хуулиа зөрчиж байгаа юм бид төрийн бодлого барьж байгаа удирдах албан тушаалд ажиллаж байгаа төрийн албаны хүмүүс бид хуулийнхаа хүрээнд л ажиллана үзэмжээр биш, өнгөөр биш бид нар хууль зөрчиж ямарваа асуудалд орох юм бол эрсдэлд орно энэ өвс, тэжээл бол сумын аюулгүй нөөц энэ нь Богд сумын 1015562,0 га газар дээр аль нэг газар байгалийн болзшгүй эрсдэл учрах юм бол үүнд тусламж үзүүлэх л өвс, тэжээл бусдаар сумын нийт иргэдэд зүгээр байхад нь май гэдэг өвс,

тэжээл биш юм зориулалт нь ийм юм. Тэгээд зах зээлийн үнээс 50 хувь доогуур байгаа юм бид 64 сая төгрөгөөр 2000 боодол ногоон өвс, 1000 шуудай хивэг аваад үүнээсээ буцаагаад 40 саяыг нь эргэлдүүлээд дахиж нэмээд дахиал тендер зарлаад ингээ л явах юм тэгэхлээр цаг сайхан тайван байгаа үед май ав гэдэг зориулалттай биш өнгөрсөн онд 2400 боодол ногоон тэжээл 1200 шуудай хивэг үлдсэн одоо сумын аюулгүй нөөцөд 4400 боодол өвстэй 2200 шуудай хивэгтэй байгаа үүнийгээ бид нар нийт нутгаар цас ороод асуудал үүсэх юм бол 1 айл ядаж 2,3 юм өгчих боломжийг л бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм үүнийг санаан зоргоор бүрдүүлчихэж болохгүй байгаа юм улсын онцгой комисс цаанаасаа шийвэр гаргаад Өвөрхангай аймгийн Богд сум ийм аюулгүй нөөц бүрдүүл үүнийг бүрдүүлэхгүй бол яагаад бүрдүүлээгүй юм О.Өлзийбадрах нөхөр яагаад төрөөс өгч байгаа ажлыг та гүйцэтгэхгүй байгаа юм гэж буцаагаад асуудал үүснэ тийм болохоор бид төлөвлөгөөнийхөө дагуу төлөвлөж явж байгаа бусдаар хэн нэгэн дарга солигдоод сайн дураараа юм хийгээд байгаа юм биш энэ бол заавал байдаг зүйл Д.Дэмбэрэл гуай малын хөлийн татвараа өгдөггүй хүмүүст авах арга хэмжээг тодорхой болгох ёстой гэж байна тантай санал нэг байна тэгэхлээр бид нар тухайн малын хөлийн татвараа тухайн оны 01-р сарын 1-ээс 12-р сарын 15-ны хооронд төлөх ёстой хуулийн хугацаа энэ хугацаанд төлөхгүй бол бид ямар арга хэмжээ авах юм цаанаасаа бол хуулиараа дансыг нь хаа гэнэ тусламж дэмжлэг өгөхгүй байж болно эргээд нийтийг хамарсан зүйл дээр малчин дорж, долгор малын тоо толгойн албан татвараа төлөөгүй байж би малчин надад юм өгсөнгүй асуудал байгаа юм бид цаашдаа нийтийг хамарсан тусламж дэмжлэг дээр малын тоо толгойн албан татварыг заавал харгалзана манай сум газар нутаг томтой малчин өрх олонтой учраас нийт малчдад хүрэлцээтэй тусламж дэмжлэг ирдэггүй юм тэгэхлээр нэн тэргүүнд малын хөлийн татвараа төлдөг нийгмийн хариуцлага үйл ажиллагаанд оролцдог ийм малчдаа анхаарч үзэхээс аргагүй юм манай иргэдийн өөрсдийн нь үүрэг хариуцлага ухамсрын асуудал байгаа юм.

Сонсгол даргалагч: Санал хэлэх оролцогч байна уу?. Байхгүй байна саналаа хаалаа.

Сонсголтой холбогдуулж ИТХ-ын дарга С.Баттогтох дүгнэлт хэлнэ.

С.Баттогтох иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга: Өнөөдөр Нийтийн сонсгол маань амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү нийтийн сонсголыг зохион байгуулснаар Малын тоо толгойн албан татварын хэмжээ түүний ач холбогдол иргэдийн ойлголт нэмэгдэж оролцоог хангасан үр дүнтэй сонсгол боллоо гэж бодож байна. Малын тоо толгойн албан татвараар хийгдэж байгаа хийгдэж байгаа ажлуудын талаар дэлгэрэнгүй ярилцлаа цаашид энэхүү сонсголд яригдсан

саналуудыг бид цаашдынхаа бодлого шийдвэрт тусгаж төлөвлөж ажиллах болно.

Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Сонсгол даргалагч: ИТХ-ын дарга С.Баттогтохдоо баярлалаа. Малын тоо толгойн албан татавараар 2022-2025 онд хийгдсэн ажлын үр дүн, зарцуулалтад хийх төсвийн хяналтын сонсгол амжилттай зохион байгуулагдаж өндөрлөж байна.

Хүрэлцэн ирсэн та бүхэндээ Баярлалаа.

Сонсгол 15 цаг 48 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:


СОНСГОЛ ДАРГАЛАГЧ

Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Ц.ОЮУНБИЛЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ИТХ-ЫН МЭРГЭЖИЛТЭН  С.МЯГМАРСҮРЭН